

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“ДЦС-4” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос [Зуухны гүүрэн кран №1, №2 КМ-50/10] засварын ажил хийх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Тендер нь түүнийг нээсэн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээс үнэ төлбөргүй авч болно.

Үнийн саналыг **2020 оны 05-р сарын 07-ны өдрийн 10.000 цагаас** өмнө Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр илгээх бөгөөд 1 хувийг цаасаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 05-р сарын 07-ны өдрийн 10.30-т цахимаар нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг дээрх цахим хаягаар орж авч болно.

“ДЦС-4” ТӨХК ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ХЭЛТЭС
Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж
Захиргааны байр 3-р давхар 310,312 тоот өрөө
Утас:70181309, 7000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

“ДЦС-4” ТӨХК

Огноо: 2020 оны 04 дугаар сар 30

Зуухны гүүрэн кран №1, №2 КМ-50/10 засварын ажил гүйцэтгэх тендерийн баримт бичиг

Харьцуулалт/гэрээний
дугаар:

АҮ-2020/25

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ү.ТӨМӨРХУЯГ

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч, тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдоод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/болон бусад баримт бичиг;
 - (г) Тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт
 - (д) Мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн үнэмлэх
4. **Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 2 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.

хугацаа

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр, тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн нэг жилийн санхүүгийн баталгаажсан тайлан</p> <p>Бусад нэмэлт шаардлага: Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар, Ачаа өргөх кранд үл эвдэх сорилт хийж дүгнэлт гаргах эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй байгууллага байх Үл эвдэх сорилын соронзон санамжийн аргыг хийх мэргэжлийн эрх бүхий 1-2-р түвшний инженер техникийн ажилтантай байна. Инженер техникийн ажилтан нь краныг оношлон шинжлэх ажилд оролцсон байна. Тухайн аргыг хэрэглэн техникийн оношлогоо хийх туршлагатай байна. Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх аюулгүй ашиглах дүрмийн хавсралт №9 дагуу краны замд хэмжилт хийж дүгнэлт гаргах чадвартай байна</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 05-р сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минут Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn Сайтад илгээх бөгөөд нэг хувийг цаасаар ирүүлнэ</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер нээх хаяг, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: “ДЦС-4” ТӨХК Худалдан авах ажиллагааны хэлтэс Улаанбаатар хот Баянгол дүүрэг 20-р хороо Эрчим хүчний гудамж</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Захиргааны байр 3-р давхар 310 тоот өрөө</p> <p>Огноо: 2020 оны 05-р сарын 07-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Зуухны гүүрэн кран №1, №2 КМ-50/10 засварын ажил хийх нэр бүхий 1 багцаас бүрдэнэ</p>

Дөрөв. АЖЛЫН ЭЗЭЛХҮҮН



Зуухны гүүрэн кран №1-т металлын үл эвдэх сорилт хийх ажлын эзэлхүүн

№	Хийгдэх ажлууд	Х/н	Тоо	Тайлбар	
1	Гүүрэн краны дам нурууны төгсгөл	м	8	Хүчдэл төвлөрөх шугамыг тодорхойлох, цууралт илрүүлэх, зэврэлт илрүүлэх зорилготой	
					Галнаасан холбоос дахь цууралт шалгах
					Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах
2	Үндсэн дам нуруу	м	132		
					Угсарсан метал хэсгийн ачааллаас гажилт өгөх бүсийн цуцалт шалгах
					Угсарсан метал хэсгийн ачааллаас гажилт өгөх бүсийн цуцалт шалгах
3	Дэгээ болон дэгээний төхөөрөмж	ком	2		
				Хүчдэл төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	
				Дэгээний бие дэх цууралт шалгах	
				Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	
4	Алслалын дутаар огтлолын дам нуруу	м	41	Цууралт илрүүлэх, зэврэлт илрүүлэх зорилготой	
5	Ган татлагат дамран систем	м	384		
6	Краны дугуй, тэргэнцэрийн дугуйнууд	ш	14		

Зуухны гүүрэн кран №2-т металлын үл эвдэх сорилт хийх ажлын эзэлхүүн

№	Хийгдэх ажлууд	Х/н	Тоо	Тайлбар	
1	Гүүрэн краны дам нурууны төгсгөл	м	8	Хүчдэл төвлөрөх шугамыг тодорхойлох, цууралт илрүүлэх, зэврэлт илрүүлэх зорилготой	
					Галнаасан холбоос дахь цууралт шалгах
					Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах
2	Үндсэн дам нуруу	м	132		
					Угсарсан метал хэсгийн ачааллаас гажилт өгөх бүсийн цуцалт шалгах
					Угсарсан метал хэсгийн ачааллаас гажилт өгөх бүсийн цуцалт шалгах
3	Дэгээ болон дэгээний төхөөрөмж	ком	2		
				Хүчдэл төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	
				Дэгээний бие дэх цууралт шалгах	
				Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	
	Эд ангийн ачааллаас гажилт өгөх бүсийн цуцалт шалгах				
	Дэгээний ачаалал авах хэсгийн хөндлөн огтлолын элэгдэл шалгах				

4	Алслалын двутавр огтлолын дам нуруу	Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	м	41	Цууралт илрүүлэх, зэврэлт илрүүлэх зорилготой
5	Ган татлагат дамран систем	Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	м	384	
6	Краны дугуй, тэргэнцэрийн дугуйнууд	Ачаалал төвлөрлөөс үүсэх цууралт шалгах	ш	14	

Зуухны гүүрэн краны замд хэмжилт хийх ажлын эзэлхүүн

№	Хийгдэх ажлууд	Х/н	Тоо	Тайлбар
1	Нэг хөндлөн огтлол дахь зам төмрийн толгойн зөрүү, P1 мм /алслал/	м	336	Гүүрэн краны зам төмрийн төлөв байдлыг тодорхойлох зорилготой
2	Зэргэлдээ тулгуур дахь зам төмрийн зөрүү P2 мм	м	336	
3	Зам төмрийн царигийн хэмжээний өргөсөлт ба нарийсалт, P3 мм	м	336	
4	Зам төмөр залгагдах хэсэг дэх өндрийн зайн хэмжээний зөрүү P4 мм	ш	6	
5	Зам төмөр залгагдах хэсгийн завсрын зайн хэмжээний зөрүү P5 мм	ш	4	

ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕРИЙН ОРЛОГЧ

 Р. ГАНБАТ

ЗА-НЫ ДАРГА



Ц. АМАРБАЯСГАЛАН

МЦ-ИЙН ДАРГА



Д. ЭНХБҮРЭН

ГҮЙЦЭТГЭСЭН:

МЦ-ИЙН ЗАСВ. ИНЖЕНЕР



Д. ЭНХБОЛД

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Өгөгдсөн ажлын эзлэхүүний дагуу “Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжуудыг засварлах хөдөлмөрийн нэгтгэсэн норм ЭХН-8-81-02-2007” ном үндэслэн төсөв зохионо.

Төсөвт ажлын тарифт цалинг “ДЦС-4” ТӨХК-ий гүйцэтгэх захирлын 2018 оны 10-р сарын 10-ны өдрийн А/235 тоот тушаалын дагуу тооцно.

“ДЦС-4” ТӨХК-ийн
Гүйцэтгэх захирлын 2018 оны 10
дугаар сарын 10-ний өдрийн А/235
дугаар тушаалын хавсралт

Эрчим хүчний тоноглол, барилга сантехникийн засварын төсөвт ажлын жишиг тарифт цалин

Төгрөг

1.0	2,285.71	2.0	2,537.14	3.0	2,857.14	4.0	3,291.43	5.0	3,794.29	6.0	4,388.57
1.1	2,310.86	2.1	2,569.14	3.1	2,900.57	4.1	3,341.71	5.1	3,853.71		
1.2	2,336.00	2.2	2,601.14	3.2	2,944.00	4.2	3,392.00	5.2	3,913.14		
1.3	2,361.14	2.3	2,633.14	3.3	2,987.43	4.3	3,442.29	5.3	3,972.57		
1.4	2,386.29	2.4	2,665.14	3.4	3,030.86	4.4	3,492.57	5.4	4,032.00		
1.5	2,411.43	2.5	2,697.14	3.5	3,074.29	4.5	3,542.86	5.5	4,091.43		
1.6	2,436.57	2.6	2,729.14	3.6	3,117.71	4.6	3,593.14	5.6	4,150.86		
1.7	2,461.71	2.7	2,761.14	3.7	3,161.14	4.7	3,643.43	5.7	4,210.29		
1.8	2,486.86	2.8	2,793.14	3.8	3,204.57	4.8	3,693.71	5.8	4,269.71		
1.9	2,512.00	2.9	2,825.14	3.9	3,248.00	4.9	3,744.00	5.9	4,329.14		

	251.43	320.00	434.29	502.86	594.29
	25.14	32.00	43.43	50.29	59.43

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Техникийн тодорхойлолтод заагдсан ажлын эзлэхүүний дагуу гаргасан график, түүнд үндэслэсэн үе шатны ажлын хуваарь ирүүлнэ.

Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|--|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежер хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаадуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд |

- багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.

18. Гэрээг цуцлах

18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.

18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:

(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;

(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;

(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор таган буугдсан;

(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;

(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.

18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр

19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.

19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.

20. Гүйцэтгэлээс чөлөөлөх

20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

**21. Ажлын тоо
хэмжээг
өөрчлөх**

21.1. Захиалагчийн саналаар нэмэгдэл ажил хийгдэх, төсөвт ажилбар, материал, тээвэр, механизмын зардал дутуу тусгагдсан, үнийн зөрүү гарсан тухай бүр хоёр тал харилцан тохиролцон, акт, протокол үйлдэн баталгаажуулж шийдвэрлэнэ.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 1.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: АҮ-2020/25
ГЕН 1.2	Ажил Зуухны гүүрэн кран №1, №2 КМ-50/10 засварын ажил хийх гүйцэтгэх
ГЕН 3.1	Төслийн менежер нь Засварын алба
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Захиалга өгсөн өдөр Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Захиалга өгөхөд заасан хугацаа
ГЕН 6.1	Талууд гэрээтэй холбоотой асуудлаар гарах маргаан зөрчилдөөнийг аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг хичээнэ. Маргаан зөрчилдөөнийг 30 хоногийн эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй бол дараа шүүхэд шийдвэрлүүлэхээр хандаж болно.
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 2 жил байна.
ГЕН 13.1	Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 % байна. Нийт ажилд ноогдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн Гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 30% байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусгаагүй ажлын 50хувиар тооцно.

\

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

ГЭРЭЭ.

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас “ДЦС-4” ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны -р сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь “ _____ ”-ыг (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: [гэрээний үнийг тоогоор] төгрөг болно.

4. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг 2020 оны 0

дугаар сарын 01-ны өдрөөс 2019 оны _____ дугаар сарын _____ өдөр хүрэл хугацаанд үргэлжлэнэ. Технологийн шалтгаанаар ажлын байр бэлтгэхтэй холбогдон эхлэх хугацаа хойшилсон тохиолдолд наряд нээгдсэн өдрөөс эхэлсэнд тооцно.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээ

10.нд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

11. Гэрээг 3 хувь үйлдэж захиалагч 2 хувь, гүйцэтгэгч 1 хувийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй

12. Гэрээг 3 хувь үйлдэж захиалагч 2 хувь, гүйцэтгэгч 1 хувийг хадгалах ба тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй